Golomt Capital®

ЗЭСИЙН ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

2022 оны 2-р сарын 7

Долоо хоногийн онцлох үйл явдал

Өнгөрсөн долоо хоногт БНХАУ-ын цагаан сарын баяр тохиосноор Шанхайн таваарын бирж ажиллаагүй. Харин Нью-Йоркийн Comex таваарын биржид арилжаалагдаж буй зэсийн 3 сарын гэрээний ханш даваа гарагт 4.3295 ам.доллар дээр нээгдэж баасан гарагт 4.4742 ам.доллар дээр хаагдсанаар 3.3 хувийн өсөлт үзүүлжээ.

Дэлхийд зэсийн олборлолтоороо хоёрт бичигддэг Перу улсын олборлолт 2021 онд 7 хувиар өсөж 2.3 сая тоннд хүрсэн байна. 2021 онд тус улсад уурхайн олборлолтыг эсэргүүцсэн хэд хэдэн бослого гарч үйл ажиллагаа нь саатсан ч олборлолтоо амжилттай явуулж чадсан байна.

Тус улсын нийт зэсийн олборлолтын 80 гаруй хувийн 5 уурхайн төсөл хангадаг байна. Үүнд Antamina 20 хувь, Southern Copper 17.3 хувь, Cerro Verde 18.2 хувь, Las Bambas 12.6 хувь, Chinalco 10.3 хувь тус тус байдаг байна.

CRU Group-ийн мэдэгдсэнээр 2030 он хүртэл зэсийн зах зээлд 4.7 сая тоннын хомсдол үүссэн бөгөөд зэсийн нийлүүлэлтийн ихэнх хувь хэдхэн уурхайнд төвлөрч байгаа нь ирээдүйд нийлүүлэлт саатах, их хэмжээний хомсдол үүсэх эрсдэлтэй байгааг сануулж байна.

Чили, Перу зэрэг томоохон улс орнуудын олборлолтод саатал үүсэх эрсдэл нь зэсийн ханшийг ирээдүйд өсгөх томоохон хөшүүргүүдийн нэг юм.

Мэдэгдэл: Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг яттасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.